

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2020.03.19, №10 (139)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№519

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

НИЙТИЙН ХӨРӨНГӨ (COMMONS)

“Алсын хараа 2050”-ийн
шүүмж 5: Ногоон хөгжил



ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Ц.Батболд

Хөгжлийн эдийн засагч (PhD),
олон улсын хуульч

ТҮҮХИЙН СУРГАМЖ

IV НҮҮРТ



НИЙТЛЭЛ

Т.БОЛДГЭРЭЛ

ТҮВД агентурын захирал

АКАДЕМИК АЖИЛГҮЙЧҮҮД

VI НҮҮРТ



НИЙТИЙН ХӨРӨНГӨ (COMMONS)


Монгол улс 2050 он гэхэд “ногоон хөгжлийн” бодлого хэрэгжүүлж

- байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах
- байгалийн нөөц баялагийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх
- усны нөөцийн хомсдолоос сэргийлж хуримтлуулан, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцлийг бүрдүүлэх
- нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах зорилтууд тавьжээ. Эдгээр зорилтоос цаг үеийн шаардлагын түвшнээс хамаарч хүлэмжийн хий болон цөлжилтийн асуудлыг энд онцолж байна.

ХҮЛЭМЖИЙН ХИЙ

2016 онд Монгол улс “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний зорилт”-ын дагуу хүлэмжийн хийн ялгарлаа 2030 он гэхэд 14 хувиар бууруулах үүрэг хүлээсэн. Засгийн газар 2019 онд хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг салбаруудаа тогтоож, хэзээ ямар хэмжээгээр бууруулахаа мэдэгдэв. Монголын хүлэмжийн хийг үндсэндээ эрчим хүчний болон мал аж ахуйн салбарууд голлож ялгаруулдаг. Хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн бүтэц хэвээрээ байвал дараах төлөвтэй байх ажээ. ▶▶

Зураг 2: Хүлэмжийн хийн ялгарлын хэтийн төлөв, салбараар



Эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан

Эрчим хүчний салбар дангаараа нийт хүлэмжийн хийн талыг ялгаруулж байна. Гол эх үүсвэр нь нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааны станцууд. 2016 оны байдлаар манай улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн эх үүсвэрийн 92.7 хувь нь нүүрс байгаа нь дэлхийд гуравт, Ботсван, Косовагийн дараа жагсааж байна. (Монгол улсын эрчим хүчний үр ашиг, хүртээмж, түүнд хийсэн бүтцийн шинжилгээ 2019).

Хүлэмжийн хийг тогтвортой бууруулахын тулд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж, 2020 он гэхэд нийт эрчим хүчний суурилагдсан эх үүсвэрийн 20 хувийг, 2030 он гэхэд 30 хувийг орлуулах шийдвэрийг 2015 онд баталсан Төрийн эрчим хүчний талаар баримтлах бодлогод тусгажээ. Монгол улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй, нар, салхины эрчим хүчийг ашиглах

суурилагдсан хүчин чадал нь бараг 20 хувийг нь хангаж чадахуйц болсон ч борлуулалтын үнээсээ хамаараад үйлдвэрлэлд эзлэх хэмжээ нь бага хэвээр байна. Эгийн голын усан цахилгаан станцаа барьж чадахгүй, хойд хөршийн эсэргүүцэлтэй тулгараад байна.

Хэдийгээр сэргээгдэх эрчим хүч нь байгаль орчинд ээлтэй ч, Монголд эдийн засгийн хувьд үр ашигтай биш. Хамгийн бодитой сонголт нүүрс хэвээрээ байна. Монгол улс 2014 онд 34 сая тонн CO₂-той дүйцэх хүлэмжийн хий ялгаруулсан нь дэлхийн 0.1 хувийг эзлэж байна. Хөгжиж буй орны хувьд хямд нүүрсний эх үүсвэрээ одоогийн түвшинд нь ашиглаад цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангаж чадвал сайн хэрэг болно.

ЭЗЭНГҮЙ БЭЛЧЭЭР БА ЦӨЛЖИЛТ

Монгол бол уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хамгийн их хохирол амсах арван орны нэг (Дэлхийн уур амьсгалын эрсдлийн индекс 2014). Өнгөрсөн 79 жилийн хугацаанд манай орны газрын гадарга орчмын жилийн агаарын дундаж температур 2.24C хэмээр дулаарсан (Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан). 1996 оноос хойш байгалийн гамшигт үзэгдэл хоёр дахин нэмэгдлээ (Азийн Хөгжлийн Банк 2017). Тийм ч учраас хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэнд оруулахыг Алсын Хараа 2050-д зорьжээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ядуурал, тэгш бус байдал цаашид гүнзгийрэх эрсдэлд дэлхий нийтээр санаа зовниж байна. Монголд хөдөөнөөс хот руу шилжин суурьшсанаас үүдэлтэй ядуурал, тэгш бус байдал үүсч байна. Мөн Монгол үндэстний уламжлал, соёл болсон нүүдлийн мал аж ахуй ч эрсдэлд орох болов.

Өнөөдөр Монголын 171 мянган малчин өрхийн амьжиргааны гол эх үүсвэр нь бэлчээр. Гэтэл нийт нутаг дэвсгэрийн 70 хувьд бэлчээрийн даац хэтэрсэн. Тэр хэмжээгээр газар нутаг цөлжиж, бэлчээрийн экосистемд аюул учраад байна. Эрчимтэй дулаарч эхэлсэн 1990-ээд ►►

► оноос хойш 30 жилийн дотор малын тоо толгой 25 саяас 3 дахин өсөв. Бэлчээр эзэнгүйн улмаас нийт бэлчээрийн 22 хувь буюу, 25 сая га бэлчээр сэргэхээргүй доройтжээ. Энэ бол “нийтийн хөрөнгийн эмгэнэл”-ийн (tragedy of the commons) нэг тод жишээ юм.

Бэлчээрийн даацад нь нийцсэн хэмжээгээр уламжлалт мал аж ахуйгаа хөгжүүлж, тоонд биш чанарт анхаарсан бодлого явуулах шаардлагатай боллоо. Шийдэх нэг арга нь малын хөлийн татвар. Бэлчээрийн даац хэтэрсэн, олон малтай нутагт өндөр татвар ногдуулах цаг болжээ. Татварын орлогыг тухайн нутаг дэвсгэрийн бэлчээрийг сэргээн хамгаалахад эргээд зарцуулах, зарцуулалт нь ил тод байх ёстой. Мөн мал аж ахуйн салбарын судалгаа шинжилгээг сайжруулж, инноваци бий болгоход хөрөнгө оруулж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Гэхдээ зөвхөн татвар тогтоох, эсвэл бэлчээрийн газрыг хувьчлах зэргээр байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах чадахгүй. Нийтийн хөрөнгийн эмгэнэлд цэг тавих гол шийдэл бол нутгийн иргэд өөрсдөө гэдгийг Нобелийн шагналт эдийн засагч Элинор Остром олон жилийн ажиглалт, судалгаагаараа баталжээ. Япон, Швейцар, Испани, Филиппиний туршлагыг судлаад нийтийн хөрөнгийг зүй зохистой ашиглах 8 зарчмыг гаргав. Үүнд:

1. нийтийн хөрөнгийн хил хязгаарыг тогтоох, ашиглагчдыг тодорхойлох
5. нийтийн хөрөнгийг ашиглах журам нь орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн байх
3. нийтийн хөрөнгийг ашиглах дүрмээ өөрчилж, сайжруулахад хамааралтай бүх хүн оролцох
4. нийтийн хөрөнгийг хяналттай байлгах, эгэх хариуцлага чухал
5. ашиглалтын дүрэм зөрчигчдөд тохирсон шийтгэл, торгуультай байх
6. зөрчлийг өртөг багатайгаар шийддэг байх

7. нийтийн хөрөнгийг ашиглах дүрэм, журмыг тухайн орон нутгийн засаг захиргаа нь хүлээн зөвшөөрөх
8. нийтийн хөрөнгийг ашиглагчид бусадтай хамтран ажилладаг байх зэрэг оржээ.

Швейцарийн Альпийн уулархаг нутагт байрлах Төрбэл тосгонд 600 орчим хүн амьдардаг. 1483 онд тосгоныхон бэлчээр, газар, ой шугуйгаа зүй зохистой ашиглах зорилгоор хамтрал (community) байгуулав. Энэ тосгонд газар худалдаж, эсвэл өөр бусад шалтгаанаар авсан хэн ч дундын мэдлийн баялагийг ашиглах ямар ч эрх эдлэхгүй. Хамтралд тэр хүнийг гишүүнээр элсүүлэх эсэхийг гишүүдийн саналаар шийдвэрлэнэ. Тус хамтралын 1517 оны “өвөлжөөний дүрмэнд” “ямар ч иргэн өвлийн улиралд тэжээж чадахаасаа илүү тооны үхэр Альпийн газарт оруулахыг хориглоно” гэжээ. Мөн нийтийн хөрөнгийг (бэлчээрийг) давуу эрхтэйгээр ашиглах оролдлогод нийцсэн торгууль оногдуулж иржээ. Өвөлжөөний дүрмийг сахиулах, хянах үүргийг бүрэн эрхт-төлөөлөгч хэрэгжүүлнэ.

Тосгоны дүрэмд бүх оршин суугч саналаа өгөх ба хуулийн дагуу газрыг зохион байгуулах суурь эрх мэдлийг уг холбоонд олгодог. Холбоонд өөрийн үхэртэй тосгоны бүх иргэн хамаарна. Холбоо жил тутам хуралдаж ерөнхий дүрэм, бодлогоо хэлэлцэж, төлөөлөгчдөө сонгодог. Эдгээр төлөөлөгчид газрыг зүй бусаар ашигласан торгууль ногдуулах, хурал, уулзалтуудыг зохион байгуулах, Альпийн зам, жимийг сэргээн засварлах зэрэг ажлыг хариуцах хүн авч ажиллуулдаг. Тосгоныхон энэ байдлаар нийтийн эзэмшилдээ нягт хяналт тавихаас гадна бэлчээрээ бордож, зүлэгжүүлэх зэргээр арчилдаг. Хамгийн гол нь нийтийн хөрөнгийн ашиглалттай холбоотой гол шийдвэрийг түүнийг ашиглаж буй нутгийн иргэд өөрсдөө гаргадаг. Японд төсөөтэй тосгонууд бас бий. Солонгост бас 1960 оны эцсээс “шинэ тосгон” гэсэн хөдөлгөөн өрнөж өндөр амжилтанд хүрсэн.

МОНГОЛД

Монголчууд олон мянган жилийн түүхтэй бэлчээрийн мал аж ахуйгаа авч үлдэж чадах, эсэх том сорилттой тулгараад байна. Сүүлийн 30-аад жилд мал ахуйгаа зөнд нь орхисноос, малчин бүр тооны хойноос хөөцөлдөж бэлчээрээ сүйтгээд дуусгаж байна. Бэлчээрийн асуудлыг төр засаг ч шийдэж чадахгүй болов. Энэ нөхцөлд хамгийн зөв шийдэл нь хамтрал, баг болохыг Остром олон орны

жишээн дээр харуулжээ. Тийм учраас манай багийн иргэд дээрх найман зарчмаар хамтарч хоршин, бэлчээрийн менежментээ хийх цаг нь болжээ. Мөн төр засгийн эрх баригчид тийм хөдөлгөөнийг дэмжих инстүүц, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

2020.03.18



Ц.Батболд

Хөгжлийн эдийн засагч (PhD), олон улсын хуульч

ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

ТҮҮХИЙН СУРГАМЖ

Судлаач М.Саруул-Эрдэнэ саяхан нийтлүүлсэн Дилова хутагтаас 1932 онд АНУ-ын элчин сайдад, 1942 онд Ерөнхийлөгч Ф.Д.Рузвельтд уламжлуулахаар О.Латиморт бичсэн *гурван захидал* тэр үеийн Монголын элит сэхээтнүүд олон улсын геополитикийн байдлыг одооныхоос ч илүү сайн ойлгож, 1911 онд олсон үндэсний тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө ямар хүнд нөхцөлд амиа эрсдүүлэн тэмцэж байсныг харуулаад зогсохгүй, Монголын мөнхийн эрх ашгийн тулгын гурван чулуу зарчмыг бидэнд дахин сануулжээ.

Тэрээр “1920 онд Халх Монголын засагт хан, Жалханз хутагт тэргүүлэн хутагт ван гүн түшмэл олон зөвлөж, Монголын өөртөө эзэрхэх эрхийг хамгаалахаар тогтоод тус Монголын Жавзандамба хутагт хаантнаа айлтгаж Их Америк улсын засгийн ордноо өргөснийг зөвшөөрөн хүлээсэн бөлгөө. 1921 онд Улаан Оросын цэрэг тус Монголын хэдэн залуучуудын хамт гэнэт хүрээнд орж ирээд сүрээр улаан намын засгийг байгуулж, бүх хэргийг Оросоос заан сургаж, шажныг түлхэн унагах ба өмчийн хөрөнгийг үгүй болгохыг зорьж, цаазыг хатуугаар явуулж, хүний зөвлөн хэлэлцэх эрхийг таслаж, хүн галт зэвсгийг хэрэглэж болохгүй зэрэг аргыг хэрэглэж, Орос улс манай Монголыг залгин хамтатгах санаа байдал илрэхэд олон Монголчууд жигшин гаславч арга олохгүйд адил зоригтон нар нууц зөвлөж Оросын гараас гарах арга эрэхийн тулд намайг олны төлөөлөгчид томилон явуулжээ... Ар Монголын (Чойбалсангийн) Засгийн газраас нэгэн түшмэлийг маш нууцаар илгээж:

1. Тус Монголын байгуулан бүтсэн улсыг батлан тогтоох
2. Бусад этгээд тус Монголын газар нутгийг хүчирхэн эзэрхэхийг хязгаарлах
3. Монголын нутгийн дотор аль ч улсын цэрэг буюу цэргийн туслах нарыг суулгахгүй болгох

Энэ гурван зүйлийг голчлон ард түмний эрх ашгийг батлан хамгаалах учир Америк, Англи хоёр их улс лугаа яахан нэвтрэлцэх зам олохыг маш нарийн болгоомжлон бүтээхийг тушаав. Энэ явдал түгшүүртэй учир мөн тул хэнд ч огт мэдэгдэж болохгүй, маш болгоомжлон хичээж буймуу. Хэрвээ энэ чимээг хойт Орос сонсвоос тэдгээр нөхөд амьдарч чадахгүй болох бөгөөд миний биед ч түгшүүртэй (аюултай) болмуу” гэжээ.

Дээрх 3 зорилт нийт социалист системийг хамарсан ардчилсан хувьсгалын ачаар 1990 он хүрч байж сая бүрэн биелэжээ. Монгол улс 3 зууны дараа анх удаа өөрийн бие даасан эрх мэдэл, гадаад бодлоготой болж, дэлхий дахинтай чөлөөтэй харилцах бололцоотой болов. Улмаар хүний эрхийн НҮБ-ын зарчмуудыг хангасан ардчилсан засаглал, хувийн өмч, эдийн засгийн эрх чөлөөнд тулгуурласан зах зээлийн системд шилжсэнээр хүн төрөлхтний нийтлэг

хөгжилд нэгдэв. Энэ нь мөнхийн хоёр хөрштэйгөө найрсаг хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлэх, түүхэн тодорхой нөхцөлд төлөвшиж тогтсон тэгш бус харилцааг засч тэнцвэржүүлэх боломж байв. Ялангуяа гуравдагч орнуудын өндөр технологи, хөрөнгө хүчийг татах замаар Монголын харьцангуй давуу тал болох уул уурхайн баялагийг эргэлтэд оруулан, хөршүүдийнхээ асар том зах зээлд нийлүүлэх замаар эдийн засгийнхаа хөгжлийг хурдасгаж, бүтцийн шинэ шатанд дэвшүүлэх боломж нээгдэв. Үүнд Оюу толгой ба Таван толгой төслүүд шийдвэрлэх үүрэгтэй байв.

Харамсалтай нь сүүлийн жилүүдэд би хүртэхгүй л юм бол чамаар хийлгэхгүй (rent - seeking), миний улс төрд л тус болж байвал нийтээрээ хохирох нь падгүй (populism) гэсэн мугуйдал явагдсаар өнөөдөр энэ хоёр төсөл гацаа, сэхээний байдалтай болсон байна. Хамгийн аймшигтай нь хууль журмын хүрээнд ажил үүргийнхээ дагуу тэдгээр гэрээ төслийг байгуулах буюу боловсруулах ажлыг удирдсан Ерөнхий сайдуудаа улсаа худалдсан авлигач нэр зүүлгэн, бие даасан шүүх, хууль хангах нотолгоогүйгээр гэмт хэрэгт татахыг оролдож байна. Нэгийг нь шалгаж мөрдөж байна гэж 2 сар шоронд хорьж, нөгөөг нь шүүх хэрэгсэхгүй болохоор прокуророо сольж байгаад батлагдаагүй төсөл, саналыг нь нотолгоо болгон насаар нь хорих хүртэл шийтгэлтэй терроризмын ял тулгаж байгаа юм байна. Бас нэг Ерөнхий сайд, өмнөх Ерөнхийлөгч ийм хэлмэгдэлд өртөхөөс айгаад эх орондоо ирж чадахгүй, магадгүй улс төрийн орогнол хөөцөлдөж явна гэж мэдээлж байна. Хамгийн гол нь хууль хүчний байгууллагад нөлөөлж, хүмүүсийн ажил бизнесийн өө сэв, өөрт нь байхгүй бол ах дүүг нь барьцаалан амыг нь үддэг Сталинист арга амилж байгаа мэт (Сталин Ленинийн засагт хамт ажиллаж, өөрийг нь боловсролгүй гэж голж байсан нөхдийгөө хэргээ хүлээвэл гэр бүлийнхнийг чинь оролдохгүй гэж цааш харуулаад, үнэнч Молотовынхоо эхнэрийг нь Гулагт хорьчихоод олон жил гадаад сайдаар ажиллуулж байсныг Хрущёв сүүлд Монголд элчингээр цөлсөн байдаг).

Эл байдал нь Монголыг дэмждэг байгууллага хүмүүсийг сэрджийлгэж, Монгол чинь ардчилал зах зээлийн шилжилтийн ололтоосоо ухраад зогсохгүй, Африк, Латин Америкт тархмал байсан хууль хүчнийхнийг гартаа оруулан

улс орноо дарамталдаг ‘tin-pot-dictator’ дарангуйлал руу гулсах нь уу гэж санаа зовоход хүргэж байна. Зарим нь бүр гадны нөлөө биш биз гэж гайхаж байна. Ажлаа хамгийн сайн хийсэн, баруунтай дорвитой харилцаа хөгжүүлж чадах Монголдоо л ховор боловсрол туршлагатай Ерөнхий сайдуудаа яагаад Элчин сайдаас нь татах гээд байгаа юм бэ гэж асууж байсан хүн одоо, Орост яагаад цэргийн зөвлөхөө элчингээр томилж байгаа юм бэ, уламжлалт цэргийн харилцаа тусламжийг сэргээн гэдэг чинь Монголыг эргээд Оросын дагуул болгох биш үү, онгоц танкаар байлдаж Монгол ялах дайсан та нарт хэн байна аа гэж асууж байна.

Зүүн тийш Оросоор гарах төмөр зам чинь түр зуурын ямар ч хөнгөлөлт аваад ашигтай болохгүй шүү, хоёр Солонгос, Орос-Японы энхийн гэрээ зэрэг дэлхийн хоёрдугаар дайнаас үлдсэн шийдээгүй хэцүү асуудлуудтай, эдийн засгийн интеграци хөгжүүлэх гэж НҮБ 30 шахам жил төсөл хэрэгжүүлж үр дүнд хүрэхгүй байгаа бүс нутаг шүү гэж зөвлөж байна. Үнэхээр Алс Дорнодоо эсгүйрүүлэхгүй хөгжүүлэх, ялангуяа Владивосток, түүнээс дулаан байнгын ажиллагаатай боомт хүрсэн дот төмөр замтай болох нь Оросын байнгын хүсэл бэрхшээл байсан бөгөөд Ялтын гэрээгээр буцааж авсан төмөр зам нь байнгын алдагдалтай, хамтран ашиглах гэхээр Мао асар их хөрөнгө оруулалт шаардсан тул БНХАУ-д үнэ төлбөргүй шилжүүлсэн *байдаг*.

Ер нь Таван толгойн хорлон сүйтгэл гэж юуг хэлж байна вэ? Уул уурхайн онцлог чинь гадныханд өгчих өмч гэж байхгүй, нөөц баялагаа олзворлож зараад л цалин хөлс, татвар royalty, ашиг хүртэх, тэр нь далайцтай удаан л байвал унац ихтэй ажиллагаа шүү дээ. Тэр үеийнх шиг ашигтай юм хийх нөхцөл бололцоо аль эрт байхгүй болсон. Томхон төсөл хэрэгжүүлвэл хувьцаа эзэмшигч бүх иргэдээс асуудаг, ашгийг нь төр аваад тараачихдаг буюу огт өөр төслүүдийн санхүүжилтэд зарчихдаг төрийн компанийг олон улсын IPO хийнэ гэж хэзээ ч бүтэхгүй. Одоо юу гэж нэрлэх нь хамаагүй, хамгийн гайгүй нөөцөө барьцаалсан бонд зээлийн шинжтэй л юм болж дуусна байх. Түүний үр ашиг өмнөх төслөөс олон дахин дутуу төдийгүй, төлж дийлэхгүй байгаа төрийн өрийг нэмэгдүүлэх аюултай.

Эдгээр Ерөнхий сайдуудаа шийтгэлээ гэхэд давж заалдах дотоодын үе шат дуусмагц тэд олон улсын хүний эрхийн шүүхэд хандах эрхтэй болно. Тэнд Монголын биш *олон улсын хууль стандартаар үнэхээр Оюу толгой өгсөн авлига, Хятадын компани олсон ашиг хохирол нотлогдохгүй* бол гэмт хэрэг бүрдэхгүй. Эцэст нь улс төрийн хэлмэгдэгсдээ суллахыг олон улсын хамтын нийгэмлэг байнга шаардсан, бололцоотой чадалтай нь гадаадад зугтаж орогносон бусад цээрлэдэг “shithole” орон болж, хожмын нэг засаг өнөөгийн Судан шиг өмнөх Ерөнхийлөгчөө олон улсын шүүхэд өгч байх замд орохыг үгүйсгэх аргагүй.

Монголыг өнөөдөр коронавирусаас дутахгүй олон бэрхшээл хүлээж байна:

1. Коронавирус дарагдахгүй сунжирвал машинаар зөөж болохгүй нүүрсээ урагшаа ачуулах төмөр замын ажлыг яаж түргэсгэх вэ?
2. ОУВС-тай байгуулсан гэрээгээ зөрчиж програм зогсоосны улмаас сонгуулийн дараагаас өрөө төлж чадахгүй дефолтод орох бол яах вэ?
3. Дулаарлын улмаас нян идэвхжиж байгаа өнөөгийн нөхцөлд ган зуд, малын өвчинд нэн өртөмхий бэлчээрийн мал аж ахуй хүндэрвэл яах вэ?
4. Оюу толгой, Таван толгойтой харилцаа, хайгуулын лиценз журамлал, Үндсэн хуульд оруулсан зарим өөрчлөлтийн улмаас гуравдагч хөршийн хувийн хөрөнгө оруулалт орж ирэх найдвар үндсэндээ байхгүй болоод байгаа уул уурхайн салбар хүндэрвэл валютын өөр ямар эх үүсвэрээр импортын хэрэгцээгээ залгуулах вэ?
5. Ямар салбарууд өөрөө хөгжиж, холын төлөвлөгөө гэсэн хоосон мөрөөдлүүд биелэгдэх юм бэ?

Энэ бүх сорилтуудыг давахад бидэнд үндэсний эвлэрэл өнөөдөр хамгийн чухал болж байна. Байгалийн баялагийн рентээ булаацалдаж улс төрчид нь бие биенээ барьж идсэн, улс орноо сүйрүүлсэн бусад орны гашуун туршлагууд хангалттай бий. Монгол хүн болгон эх оронч болов уу, харилцан буулт хийж хамтарч ажиллаж сураагүй нь улс төрийн тоглоомын боловсон дүрэм хөгжөөгүйнх мэт. Ялангуяа сонгуулийн уур амьсгал сөргөлдөөнийг хурцатгаж хэлмэгдэл гарахад түлхэж байх шиг.

Иймээс

1. Парламентаас төрийн ажил үүргийнхээ дагуу гаргасан шийдвэрийнхээ төлөө (алдаатай алдагдалтай болсон ч) улс төрчид гэмт хэрэгт татагдах ёсгүйг баталгаажуулсан хууль гаргах (энэ нь одоогийн эрх мэдэлтнүүдийн үйлдэлд ч хамаарна)
2. Сонгууль өнгөртөл улс төрийн нөлөөлөл орсон байх магадлалтай хэргийн мөрдөлт шийдвэрлэлтийг зогсоон хойшлуулах.
3. Үндсэн хуулийн өөрчлөлтийн үзэл баримтлалын дагуу гадны нөлөөгүй, бие даасан шүүх, хяналтын байгууллагыг шинэчилсний дараа тэдгээр хэргийг шийдвэрлэхийг уриалж байна.
4. Үндсэн хуулиар олгогдсон шинэ боломжийг ашиглан, улс төр бизнесийн нөлөөнд орохгүй, бие даасан шударга шүүх, хяналтын тогтолцоо бий болгож, ийм нөлөөнд автагдаж байгаа хүмүүсээс эгнээгээ цэвэрлэж, Монголд хүний эрхийг баталгаатай болгохын төлөө тууштай тэмцэхийг нийт хуульчдад уриалж байна.

2020.03.15



НИЙТЛЭЛ

Т.БОЛДГЭРЭЛ
ТҮВД агентурын захирал

АКАДЕМИК АЖИЛГҮЙЧҮҮД

Засгийн газар "...сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам" батлах төслийг УИХ-д өргөн барив. Төсөлд жишээ нь "Эзэмшсэн мэргэжлээрээ эх орондоо болон эх орноо төлөөлөн гадаадад 5-аас доошгүй жил тасралтгүй ажиллан, нийгмийн даатгал төлсөн тохиолдолд зээлээс бүрэн чөлөөлөх" гэсэн заалт байгаа учир олон нийтийн дунд Боловсролын зээлийн сангийн зээлээр гадаадад сурсан төрийн түшмэдийн хүүхдүүдийн өрийг тэглэх гэж байна гэсэн шуугиан өрнүүлэв. Саяхан тэтгэврийн зээл тэглэснээс болоод нийгэмд бас нэг давалгаа ингэж үүслээ.

1993 онд Сургалтын төрийн сан байгуулагдаж 30 мянган иргэнд сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, 70 мянган иргэнд сургалтын төлбөрийн зээл, 1997 оноос хойш 2200 иргэн гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахдаа сургалтын төлбөрийн болон амьжиргааны зээл, 2000 оноос хойш 55 мянга гаруй төрийн албан хаагчийн хүүхэд сургалтын төлбөрийн тэтгэлэг авсан байна. Засгийн газраас баталсан журамд зааснаар дотоодын их, дээд сургуульд зээлээр суралцан төгссөн иргэний ажилласан жилийг харгалзан 2004, 2008 онд зээлээс чөлөөлж байжээ. Гэвч дээд боловсролын 14 мянган диплом, өнөөдөр 16 тэрбум төгрөгийн зээлийн "барьцаанд" байгаа тухай Боловсролын сайд Б.Баатарбилэг мэдэгджээ. Энэ нь Монголд их дээд сургууль төгсөгчид хөдөлмөрийн зах зээл дээр ямар хэмжээнд үнэлэгдэж буйг илэрхийлж байна. Суралцагч эзэмшсэн мэдлэг, чадвар-мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөн ажил, орлоготой болох замаар сургалтын зээлээ эргүүлэн төлөх ёстой. Гэтэл манай улсын дээд боловсролын тогтолцоо нь эрэлт, нийлүүлэлтийн хол зөрүүтэй, хөдөлмөрийн зах зээлтэйгээ уялдаагүй учир академик-ажилгүйчүүд "үйлдвэрлэж", сургалтын зээлээ ч төлөх чадваргүй дипломын эздийг бүтээж байгаа нь дээд боловсролын хөрөнгө оруулалтын өгөөж тун доогуур байгаагийн тусгал биш гэж үү?

Өнөөдөр дэлхий дахинд боловсролын санхүүжилтийн гурван жишиг хувилбар байна.

1. Дээд боловсрол бол хувь хүний хөрөнгө учир боловсрол эзэмшигч зах зээлийн зарчмаар сургалтаа өөрөө санхүүжүүлэх. Боловсрол олж авахад зарцуулсан хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хувь хүн өөрөө хүртдэг учир сургалтын төлбөр, бүх зардлаа өөрөө төлөх нь зөв.
2. Дээд боловсрол нь нийтийн хөрөнгө. Тийм учраас бүгдэд тэгш боломж олгож, хүртээмжтэй байхаар нийтийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх ёстой.
3. Холимог – хувийн болон нийтийн хөрөнгө оруулалтаар санхүүжих.

Эхний ангиллын том төлөөлөл болох АНУ-д дээд боловсрол эзэмшигчдийн ихэнх нь зээлээр сургалтаа санхүүжүүлдэг учир өнөөдөр АНУ-д 44 сая хүний 1.5 ихнаяд доллараар хэмжигдэх сургалтын зээлийн өр байна. 40 эргэм насандаа сургалтын зээлээсээ салаагүй байх асуудал энгийн үзэгдэл бөгөөд эргэн төлөлтийн асуудлаас үүдсэн эдийн засгийн хүндрэл ч гарах магадлалтай гэж зарим мэргэжилтнүүд үзэх нь бий.


Дараагийн ангилалд орох Скандинавын Дани, Швед, Финланд, Норвеги улсуудад сургалт төлбөргүйгээс гадна зарим нь амьжиргааны өртгийг тэтгэмжээр санхүүжүүлдэг. ХБНГУ-д сургалтын төлбөр байхгүй ч амьжиргааны өртөг зээлээр санхүүжих боломжтой. Тухайлбал Германд нийгэм, эдийн засгийн чиглэлийн бакалаврын нэг оюутны сургалтын зардал €30.000 гаруй байхад анагаах ухааны чиглэлийн оюутных €200.000 болдог. Харин энэ зардал яаж эргэн төлөгддөг вэ? Нийгмийн ухааны чиглэлээр төгсөгчийн жилийн дундаж цалин €35.000, инженер, IT мэргэжилтэн €47.000, эмчийнх €84.000. Дунджаар жилийн цалин €40.000 гэвэл хүн амын орлогын албан татварт €3.020, нийгмийн даатгалд €8.000 төлөгдөнө. Төрөөс тус оюутанд оруулсан хөрөнгө оруулалтыг зөвхөн татварын орлогоор нөхнө гэвэл 8-10 жилийн дотор, харин татвар, нийгмийн даатгалын хураамжаар хамтатган тооцвол 5-8 жилд эргэн төлөгдөж байна. Суралцагч 25 насандаа хөдөлмөрийн гараагаа эхлэж 67 насандаа тэтгэвэрт гарах одоогийн нөхцлөөр тооцвол эхний 5-8 жил нь боловсролынхоо хөрөнгө оруулалтыг нөхөөд үлдсэн 30 гаруй жилийн туршид нийтийн хөрөнгө оруулалт хийж байна гэсэн үг.

Манайх холимог ангилалд багтахаар байгаа ч Дээд боловсролын хуулийн 8-р бүлэг "дээд боловсролын эдийн засаг, нийгмийн баталгаа"-ны тухай зүйл ангиудыг 2011 онд хүчингүй болгосноос эл асуудал үндсэндээ шийдлээ хайсаар, хүлээсээр.

Аливаа улсын боловсролын тэр дундаа дээд боловсролын "бүтээгдэхүүн" хэр чанартай байхаас тухайн улсын өрсөлдөх чадвар хамаарна. Дээд боловсрол өндөр босготой бөгөөд нэгэнт шалгарсан оюутныг суралцах, хөгжих орчин нөхцлөөр хангаж, санхүүжилтийн тогтвортой, найдвартай тогтолцоо бий болгох нь чухал. Эдүгээ Монголчууд бид ямар зарчмаар дээд боловсролдоо хөрөнгө оруулалт хийх вэ, яаж санхүүжүүлэх вэ гэдгээ эргэн нухацтай харж, сайтар хэлэлцэн "цоорхой" хуулиа шинэчлэн, дээд боловсролоо өөд нь татах цаг болжээ.

2020.03.18

ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС



**TOTAL QUARTZ 9000
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

Холбоо барих утас: 9411-7143, 9906-6402



www.minesup.mn



@TOTALMongolia



fb.com/TOTALMongolia



@TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

UP
MINES
www.minesup.mn